



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/26

Алтай хот

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр санхүүжигдэх хашиж хамгаалсан булгийн тор, шонг засаж сэлбэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: А.Баасандаш (Сум дундын ойн ангийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ц.Анхбаяр (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)


Ш.Батзүсэм (Хөндлөнгийн төлөөлөл (тохиролцсоноор))

Б.Нямлхагва (Есөнбулаг сумын иргэн)

Нарийн бичгийн дарга: Б.Эрхбаяр (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2. Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай зохион байгуулан, дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг Үнэлгээний хороо (А.Баасандаш)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ